



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.БУМ-ОЧИР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.02.06 № ХЭГ/411
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265002175

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“6.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын санаачлан боловсруулсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын санаачлан боловсруулсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийг хэлэлцээд уг хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ, холбогдох бусад хууль тогтоомжид заасан ардчилсан сонгуулийн зарчимд нийцсэн, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан байх тул төслийг зарчмын хувьд дэмжсэн санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР